





Банкны салбарын эргэн тойронд

- 04.03 – Монголбанкны дэргэдэх эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэн байгуулагдлаа. mongolbank.mn
- 04.04 – ХААН Банк Сангаас 2018 онд эрүүл мэндийн хоёр том төсөл хэрэгжүүлнэ. khanbank.com
- 04.06 – Монголбанкнаас “Чанаргүй активыг бууруулах удирдлага, үйл ажиллагааны журам”-ын төслийг танилцууллаа. mongolbank.mn
- 04.10 – Кредит банк үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ой болж байна. creditbank.mn
- 04.12 – Чингис Хаан банк Q Pay үйлчилгээг нэвтрүүллээ. ckbank.mn
- 04.13 – Монголбанк 2017 онд 176,6 тэрбум төгрөгийн ашигтай ажиллав. mongolbank.mn
- 04.13 – Богд банк нь Хятадын Бошанг банк болон Өвөрмонголын банктай хамтын ажиллагааны гэрээ байгууллаа. bogdbank.mn
- 04.19 – Монгол - Хятадын бизнес форумын үеэр Худалдаа, хөгжлийн банк нь БНХАУ-ын Баошанг банктай “250 сая юанийн хамтын санхүүжилтийн зээл”-ийн гэрээнд гарын үсэг зурлаа. tdbm.mn
- 04.20 – Ногоон санхүүжилтийн 2-р чуулган амжилттай болж өндөрлөлөө. xacbank.mn
- 04.23 – Монголбанкнаас “Цахим Мөнгөний журам”-ыг баталлаа. mongolbank.mn
- 04.26 – Монголбанк, Монголын Банкны Холбоо, ХААН Банк хамтран Цахим банкны аюулгүй байдал ба төлбөрийн эрсдэл анхдугаар форумыг зохион байгууллаа. khanbank.com
- 05.10 – Монголбанк болон Засгийн газраас ипотекийн зээлд 45 тэрбум төгрөгийг банкуудад хуваарилав. mongolbank.mn
- 05.10 – Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банк нь Солонгос улсаас мөнгө шилжүүлэх үйлчилгээг илүү хялбар болгохоор БНСУ-ын E9PAY компанитай хамтран “E9Pay” үйлчилгээг нэвтрүүллээ. nibank.mn
- 05.20 – Тээвэр хөгжлийн банк хувь нийлүүлсэн хөрөнгөө 22 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 72 тэрбум төгрөгт хүргэв. Ингэснээр Монголын 7 дахь хамгийн их хувь нийлүүлсэн хөрөнгөтэй банк боллоо. transbank.mn
- 05.31 – Чингис хаан банк хувь нийлүүлсэн хөрөнгөө 15.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүллээ. ckbank.mn
- 05.31 – Тээвэр Хөгжлийн банк нь PWC компанитай “Санхүү тайлагналын олон улсын стандарт 9, 15 болон 16 дугаар стандартыг нэвтрүүлэх” зөвлөх үйлчилгээ авах гэрээ байгуулж улмаар үйл ажиллагаандаа нэвтрүүллээ. transbank.mn
- 05.31 – Хаан Банкны нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч Хаан Банк Сангаас Нийслэлийн 25-р тусгай дунд сургуулийн технологийн кабинетийг иж бүрэн засварлан хүлээлгэн өглөө. khanbank.com
- 06.06 – Монголбанк “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-д орох нэмэлт өөрчлөлтийн төслийг танилцууллаа. mongolbank.mn
- 06.06 – ХХБанк 28 жилийн ойгоо тохиолдуулан 28 дунд сургуулийн номын санг тохижуулж, номоор баяжуулла. tdbm.mn
- 06.15 – Монголын Банкны Холбоо Санхүүгийн Зохицуулах Хороотой Хамтын ажиллагааны гэрээ байгууллаа. mba.mn
- 06.15 – Шинээр томилогдсон Мөнгөний бодлогын хороо хуралдаж бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах, иргэдийн хэрэглээний зээлийн Өр-орлогын харьцааны дээд хязгаарыг 70 хувиар тогтоох шийдвэр гаргалаа. mongolbank.mn
- 06.15 – Тээвэр хөгжлийн банк MoneyGram үйлчилгээг харилцагчиддаа хүргэх Монголын 7 дахь гишүүн банкаар элсэн орж, хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурлаа. tdbm.mn
- 06.25 – Банкны салбарын тогтвортой үйл ажиллагааг хангах тухай хуулийн төсөл батлагдав. mongolbank.mn
- 06.27 – Монголбанк эко алтны үйл ажиллагааг дэмжин ажиллана. mongolbank.mn
- 06.28 – Монголбанк банкны нэгдэлд нэгдсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх харилцааг зохицуулах “Нэгдсэн хяналт шалгалтын журам”-ын төслийг боловсруулан олон нийтээр хэлэлцүүлж байна. mongolbank.mn
- 06.28 – ОУВС-гийн Захирлуудын зөвлөл 36,91 сая ам.долларын санхүүжилтийг баталлаа. mongolbank.mn

Банкны салбарын гол үзүүлэлтүүд¹



Нийт актив = 30,2 их наяд төгрөг

Банкны салбарын нийт актив 2018 оны 2-р улиралд 30,2 их наяд төгрөг болж өмнөх улирлаас 1,3 их наяд төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 4,4 их наяд төгрөгөөр өслөө.

Ашиг = 32,4 тэрбум төгрөг

Банкуудын өөрийн хөрөнгө 2018 оны 2-р улирлын байдлаар 3,18 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 4,1% өслөө. Харин банкны салбарын ашиг 2-р улирлын байдлаар 32,4 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеийн улирлын ашгаас 90 тэрбум төгрөгөөр бага байна.

Банкны нөөц = 2,9 их наяд төгрөг

Банкны нөөц 2018 оны 2-р улирлын байдлаар 2898 тэрбум төгрөгт хүрч өмнөх улирлаас 400 тэрбум төгрөг буюу 16 орчим хувиар өсчээ.

Чанаргүй зээл 9%

Нийт дотоодын зээл тогтмол өссөөр 2018 оны 2-р улирлын байдлаар 14,5 их наяд төгрөгт хүрээд байна. Харин чанаргүй зээлийн хэмжээ өндөр түвшинд хэвээр байна. 2018 оны 2-р улирлын байдлаар нийт чанаргүй зээл 1,3 их наяд төгрөг буюу нийт зээлийн 9%-ийг эзэлж байна.


¹ Эх сурвалж: Банкуудын нэгдсэн балансын гол үзүүлэлтүүд, Монголбанк

БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2018 он – II улирал


Ипотек = 4,33 их наяд төгрөг

Ипотекийн зээлийн үлдэгдэл 2018 оны 2-р улирлын байдлаар 4,33 их наяд төгрөг байна. Үүнээс 3,3 их наяд төгрөг нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл байна.




1\$=2432₮ 1¥=376₮

Монголбанкнаас зарласан ханшийн сарын дундаж хөдөлгөөнөөр 2018 оны 06-р сарын дундаж Ам.доллар-ын ханш 2432₮, Юань-ийн ханш 376₮ байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад Ам.долларын ханш 65₮-р, Юанийн ханш 29₮-р тус тус өссөн үзүүлэлт юм. (6С'18 = 2018 оны 6-р сар)




Харилцах+Хадгаламж=15,4 их наяд ₮

2018 оны 2-р улирлын байдлаар банкны салбарын нийт хадгаламжийн хэмжээ 10,7 их наяд төгрөг, харилцах 4,7 их наяд төгрөг байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж 26,4%-иар, харилцах 43,7%-иар өссөн байна.



Пассив = 27,1 их наяд төгрөг

2018 оны 2-р улирлын байдлаар банкны салбарын нийт пассив 27,1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19,2%-иар өсжээ.



Банкуудын өрсөлдөөн

Арилжааны банкны үндсэн үүрэг нь мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй байгаа хэсгээс хөрөнгийг татаж, дутагдалтай байгаа хэсэгт шилжүүлэн, харилцагчдын итгэл дээр суурилсан санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа үзүүлэх, харилцагчдын хоорондын төлбөр тооцоог хийж гүйцэтгэх бөгөөд эцсийн зорилго нь санхүүгийн үйлчилгээгээр дамжуулан ашиг олох явдал билээ.

2018 оны 2-р улирлын байдлаар банкны салбарт нийт 14 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. Монголбанкны тодорхойлсноор банкны системд нөлөө бүхий банкуудад Хаан банк, ХХБ, Голомт банк, Хасбанк, Төрийн банк, Улаанбаатар хотын банк гэсэн 6 банк багтаж байна. Эдгээр банкууд нь системийн 90-ээс дээш хувийг бүрдүүлж буй юм.

Арилжааны банкуудын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өөрчлөлт хөдөлгөөнийг харуулдаг мэдээллийн гол эх сурвалж бол банкуудын санхүүгийн тайлан юм. Банкуудын өрсөлдөөний тоймыг гаргахдаа санхүүгийн хураангуй тайланг ашиглан дараах үзүүлэлтүүдийг харьцуулсан болно. Үүнд:

- Актив
- Зээл
- Харилцах, хадгаламж
- Ашиг

Эдгээр үзүүлэлтээр арилжааны банкуудыг харьцуулахдаа активын хэмжээгээр нь Том-3 банк, Дунд-3 банк, бусад банкууд гэж ангилсан

Энэ удаагийн тайланд Капитал банкны мэдээлэл ороогүй болно. Мөн банкуудын өрсөлдөөний тоймыг Капитал банкнаас бусад 13 банкны улирлын санхүүгийн тайланг ашиглаж тооцсон учир Монголбанкнаас гаргадаг нийт банкны салбарын үзүүлэлтээс ялгаатай гэдгийг анхаарна уу.



АКТИВ

БАНКУУД

ТОМ-3 БАНК

>3 их наяд төгрөг

Худалдаа хөгжлийн банк
Хаан банк
Голомт банк

ДУНД-3 БАНК

1-3 их наяд төгрөг

Хасбанк
Төрийн банк
Улаанбаатар хотын банк

БУСАД БАНКУУД

<1 их наяд төгрөг


Капитал банк
Чингис хаан банк
Капитрон банк
Үндэсний хөрөнгө оруулалтын банк
Ариг банк
Богд банк
Кредит банк
Тээвэр хөгжлийн банк

АКТИВ




Тайлант хугацаанд тайланд орсон 13 банкны нийт актив 29.5 их наяд төгрөг байна. Том-3 банк нийт активын 70%, Дунд-3 банк 23,5%, жижиг банкууд 6,5%-ийг эзэлж байна.

1 жилийн өмнөх мөн үетэй харьцуулахад Том-3 банкны актив 16%, Дунд-3 банкны актив 18%, жижиг банкуудын актив 38%-иар тус бүр өсчээ.

Зах зээлд эзлэх хувь, активаар, 2У'18



Банкуудын активын хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлтийн хувь




ЗЭЭЛ




Тайлант хугацаанд тайланд орсон 13 банкны нийт зээл 14,3 их наяд төгрөг байна. Үүнээс 67,8%-г Том-3 банк, 25,8%-г Дунд-3 банк 6,4%-г жижиг банкууд бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Том-3 банк 16,3%-иар, Дунд-3 банк 19,6%-иар, жижиг банкууд 47%-иар тус тус зээлийн хэмжээгээ нэмэгдүүлжээ. Харин нийт дүнгээр авч үзвэл банкуудын зээлийн хэмжээ сүүлийн нэг жилд 18,7% өсчээ.

Зах зээлд эзлэх хувь, 2У'18



Зээлийн хэмжээ, тэрбум төгрөг болон өсөлтийн хувиар




ХАДГАЛАМЖ БА ХАРИЛЦАХ




Тайлант хугацаанд тайланд орсон нийт 13 банкны харилцах ба хадгаламжийн хэмжээ 17,5 их наяд төгрөг байна. Үүнээс 68,3%-г Том-3 банк, 26,1%-г Дунд-3 банк, 5,6%-г жижиг банкууд эзэлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Том-3 банк 28%-иар, Дунд-3 банк 26%-иар, жижиг банкууд 26%-иар тус бүр харилцах ба хадгаламжийн хэмжээгээ нэмэгдүүлжээ. Нийт дүнгээр нь авч үзвэл харилцах болон хадгаламжийн хэмжээ 27,7%-иар өсчээ.

Зах зээлд эзлэх хувь, 2У'18






Хадгаламж ба харилцахын хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлт



АШИГ

2018 оны 2-р улирлын байдлаар тайланд орсон 13 арилжааны банкуудын санхүүгийн тайлангийн нийлбэр дүнгээр банкууд нийт 112,1 тэрбум төгрөгийн ашигтай (татварын дараах дүн) ажиллажээ. Тайланд орсон 13 банкны хувьд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21,6 тэрбум төгрөгөөр бага ашигтай ажилласан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Том-3 банк 35%-иар буюу 39 тэрбумуаар нэмэгдүүлж 150 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ. Харин Дунд-3 банкны ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27 тэрбум төгрөгөөр буурч 2 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Жижиг банкуудын хувьд 2,1 тэрбум төгрөгийн алдагдалтай байсан өмнөх оны мөн үетэй харьцуулахад алдагдал нь 33 тэрбум төгрөгөөр ихсэж 35 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

Банкуудын ашиг, алдагдал (тэрбум төгрөгөөр):



Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень 2У'18, Монголбанк
2. Банкуудын нэгдсэн балансын гол үзүүлэлтүүд 2У'18, Монголбанк
3. Монголбанкны ханшийн сарын дундаж хөдөлгөөн, Монголбанк
4. Арилжааны банкуудын улирлын санхүүгийн тайлан 2У'18